



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 9/306

Арвайхээр

Г Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, Т  
өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн  
байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 147 дугаар тогтоолын нэгдүгээр хэсэг, Улсын Онцгой комиссын 2020 оны 26 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 26 дугаар хурлын тэмдэглэлээр гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/264 дүгээр захирамжийн 2 дахь заалтын согтууруулах ундаа худалдах заалтыг хэвээр үлдээж, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах цагийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 31-нийг хуртэлх хугацаанд 09.00-22.00 цаг байхаар тогтоосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг РС тоглоомын газар, диско баарнаас бусад бүх төрлийн хүүхдийн тоглоомын газар, биллиард, шашин, соёл, урлаг, үзвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг зөвшөөрсүгэй.

4. Хурдан морины уралдаан, уул овооны тахилга, ой тэмдэглэх, цолны мялаалга, анги хамт олны уулзалт, төрийн байгууллага, улсын болон орон нутгийн өмчит байгууллагуудын дотоодын аялал зугаалга зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

5. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100680